

Энэхүү ТМТ нь 2015 оны 8 сарын 14-ний өдрийн Англи хувилбарын орчуулга болно..



ASIAN DEVELOPMENT BANK

Монгол Улс: Богдхан уулыг тойрох Төмөр замын хөрөнгө оруулалтын хөтөлбөр

Төслийн нэр	Богдхан уулыг тойрох Төмөр замын хөрөнгө оруулалтын хөтөлбөр	
Төслийн дугаар	48329-001	
Улс орон	Монгол Улс	
Төслийн статус	Батлагдсан	
Төслийн төрөл / Тусламжийн хэлбэр	Техникийн туслалцаа	
Хөрөнгийн эх үүсвэр / Хэмжээ	ТА 8935-MON: Богдхан уулыг тойрох Төмөр замын хөрөнгө оруулалтын хөтөлбөр	
	Техникийн туслалцааны тусгай сан	1.50 сая ам.доллар
Стратегийн зорилт	Байгальд ээлтэй тогтвортой хөгжил Эдийн засгийн хүртээмжтэй өсөлт Бүс нутгийг цогцоор хөгжүүлэх	
Хөдөлгөгч хүчин зүйл	Засаглал ба чадавх хөгжүүлэх Түншлэлүүд	
Салбар / Дэд салбар	Тээвэр – Олон төрөлт тээврийн логистик – Төмөр замын тээвэр (хотын бус)	
Жэндэрийн тэгш байдал ба оролцоо	Жендэрийн зарим бүрэлдэхүүн хэсэгтэй	
Агуулга		

Төслийн үндэслэл ба Улс/Бүсийн стратегитай яалдсан байдал

Монгол Улс нь өргөн уудам нутагтай, хүн амын нягтаршил бага, далайд гарцгүй улс бөгөөд урд талдаа Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ), хойд талдаа Оросын Холбооны Улстай хиллэдэг. Газар нутгийн хэмжээ том, хүн ам тархай бутархай, цаг уурын нөхцөл хүнд тул тус улсын хувьд газрын тээвэр хүндрэл бэрхшээл ихтэй. Төмөр замын тээвэр Монгол улсын гадаад худалдаа, нийт эдийн засгийн хөгжилд эртнээс чухал үүрэг гүйцэтгэсээр ирсэн. 2013 онд Монголын нийт ачаа тээврийн 74%, зорчигч тээврийн 32%-ийг төмөр зам гүйцэтгэсэн байна. Хөрш орнуудтай хийдэг хил дамнасан худалдааны улмаас, Монгол Улсад төмөр замаар тээвэрлэгддэг ачааны хувь, автозамын тээвэр түлхүү хийгддэг бусад хөгжиж буй улс орнуудтай харьцуулахад асар өндөр байдаг. Транс-Монголын хэмээн нэрлэгддэг төмөр замын гол шугам БНХАУ-тай хиллэдэг Замын Үүд боомтыг ОХУ-тай хиллэх Сүхбаатар боомттой холбож, Улаанбаатар хотоор дайран өнгөрдөг. Тус шугам нь Транссибирийн төмөр замын сүлжээний хэсэг бөгөөд Улаан Үд хотыг Транссибирийн төмөр замын шугамтай холбодог. Мөн түүнчлэн, ОХУ-г Монгол, Хятадаар дамжуулан Зүүн Азитай холбох Төв Азийн Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Коридор 4-ийн нэгээхэн хэсэг юм.

Улаанбаатар хот дахь төмөр замын өнөөгийн үйл ажиллагаа ихээхэн үр ашиггүй байна. Төмөр замын шугам нь хотыг хоёр хэсэгт хувааж, хотын оршин суугчдын хувьд цөөнгүй саад бэрхшээлийг бий болгодог. Улаанбаатар хотоор өдөрт дунджаар 30 ачаа, зорчигч тээврийн галт тэрэг дайран өнгөрдөг бөгөөд төмөр замын 32 гарам дээр авто тээврийн хөдөлгөөний саатал үүсч, замын бөглөрлийг нэмэгдүүлж байна. Үүнээс гадна, хот даяар тархан байрласан ачаа тээврийн терминал хооронд вагоны цуваа шилжүүлэн байрлуулах ажиллагаанууд хийгддэг нь нэмэлт ачаалал бий болгодог. Учир нь импортын контейнеруудыг ачсан цувааг төмөр замын төв буудал дээр хүлээн авсны дараа хувийн хэвшлийн ажиллуулдаг контейнерийн терминалууд руу тараадаг байна. Одоогийн төмөр замын үйл ажиллагаанаас үүдэлтэй бусад сөрөг нөлөөлөлд чимээ болон агаарын бохирдлыг дурьдаж болох бөгөөд төмөр замаар ОХУ, БНХАУ руу гарах химийн бодис, бусад аюултай бараа Улаанбаатар хотоор дамждаг нь нийгмийн эрүүл мэндэд заналхийлэх тодорхой эрсдэлийг бий болгож байна. Төмөр замын үйл ажиллагаа үр ашиг муутай байгаад инженерийн байгууламжтай холбоотой зарим хүчин зүйл нөлөөлдөг. Тухайлбал, төмөр замын шугам шулуун бус, огцом муруйлттай хэсэг олон байгаа нь хөдлөх бүрэлдэхүүн, замын байгууламжийн элэгдлийг нэмэгдүүлж байна. Мөн түүнчлэн, огцом өгсүүр 2 хэсэг байдаг бөгөөд галт тэрэгний цувааг татахад нэмэлт зүтгүүр ашиглах шаардлага гардаг.

Эдгээр дайран өнгөрөх цувааг хотоос гадна байрлах хоёр дахь төмөр замын шугам руу шилжүүлснээр дээрх хүндрэл бэрхшээлийг багасгах боломжтой юм. Санал болгож буй Богдхан уулыг тойрох хоёр дахь төмөр замын шугам нь Мааньт, Рашаантын өртөөг холбох болно. Ойрын ирээдүйд, Монгол Улсаар дайран өнгөрөх төмөр замын тээвэр ихээхэн нэмэгдэх төлөвтэй байгаа бөгөөд хотыг тойрсон төмөр зам тавьснаар тээврийн эргэлтийн өсөлт хотын оршин суугчдад сөргөөр нөлөөлөхөөс урьдчилан сэргийлэх юм. Хотыг тойрсон шугам нь хот доторх төмөр замын гармууд дээрх саатлыг арилгаж, замын түгжрэл буурахад хувь нэмэр болохоос гадна аюултай ачааг хот суурин газраас холуур тээвэрлэх боломж бүрдсэнээр, аюултай бодис асгарахад хүргэж болзошгүй ослын эрсдэлийг бууруулна. Мөн түүнчлэн, Монгол Улсын төмөр замын тээврийн хүчин чадлыг нэмэгдүүлэх томоохон хөрөнгө оруулалт болохоос гадна хотод байрлах одоогийн төмөр замын байгууламжуудыг шилжүүлэн нүүлгэснээр хот төлөвлөлтөд ихээхэн ач холбогдолтой газрыг чөлөөлөх юм. Газар ийнхүү чөлөөлөгдсөнөөр орон сууц, эмнэлэг, сургууль цэцэрлэг барих боломжтой болно.

Хоёр дахь төмөр замын шугам барьж байгуулах нь 2010 оны Монгол Улсын Их Хурлын 32-р Тогтоолоор батлагдсан Монгол Улсын Төмөр замын талаар баримтлах төрийн бодлоготой нийцэж байгаа бөгөөд Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн төлөвлөгөө, Засгийн газрын 2012-2016 оны Мөрийн хөтөлбөрт мөн тэргүүлэх чиглэлээр тусгагдсан. Азийн хөгжлийн банк (АХБ)-ны Монгол Улстай хамтран хэрэгжүүлэх түншлэлийн стратегид тус тээврийн сүлжээний сул дорой хөгжил тус салбарын үндсэн асуудал болж байгааг тодорхойлсон. АХБ-ны Тээврийн тогтвортой хөгжлийн санаачилгын ажлын төлөвлөгөөнд, төмөр замыг хөгжүүлэх нь тээврийн салбарын тогтвортой үйл ажиллагаанд чухал нөлөөтэй болохыг онцолсон билээ. Үүнээс гадна, АХБ-ны 2020 он хүртэлх стратегийн завсрын шинэчлэлийн баримт нь дэд бүтцийн тогтвортой хөгжилд зориулсан дэмжлэгийг нэмэгдүүлэх шаардлагатайг тодотгон заасан.

Төслийн үр дагавар

Үр дагаврын тайлбар

Үр дагаварт хүрэх явц

Хэрэгжилтийн явц

Төслийн үр дүнгийн тайлбар

Хэрэгжилтийн явц (Үр дүн, Үйл ажиллагаа, Саад бэрхшээл)

Газарзүйн байрлал

Байгаль орчин, нийгмийн асуудлын товчоон

Байгаль орчин

Албадан нүүлгэн
шилжүүлэлт

Уугуул иргэд

Оролцогч талуудын харилцаа, оролцоо ба зөвшилцөл

Төслийн төлөвлөлтийн үед Оролцогч бүх талуудтай үр дүнтэй зөвшилцөх үүднээс зөвшилцөл, оролцоог хангах стратегийг боловсруулан төсөлд тусгана. Энэхүү зөвшилцөл, оролцооны стратеги нь нийгмийн бүлэглэл, төслийн нөлөөлөлд өртөх айл өрх, холбогдох байгууллагуудад мэдээллийг цаг тухайд нь хүргэх явдлыг баталгаажуулна. Зөвшилцөл, оролцоог хангах үйл ажиллагаанд олон нийтийн уулзалт, бүлгийн ярилцлага болон төсөлд хамрагдах нийгмийн бүлэглэл, айл өрхүүдтэй шууд харилцах бусад хэлбэрүүд хамрагдана.

Төслийн хэрэгжилтийн үед Төслийн хэрэгжүүлэгч агентлаг нь, техникийн зөвлөхүүдийн дэмжлэгтэйгээр оролцогч үндсэн талуудтай зөвшилцөн ажиллана.

Бизнесийн боломж

Зөвлөх үйлчилгээ ТБТТ-г АХБ-ын Зөвлөх үйлчилгээ авах удирдамж (2013 оны хувилбар болон нэмэлт өөрчлөлтийн хамт)-ийн дагуу олон улсын зөвлөх компанийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ. Дотоодын туршлага, орон нутгийн нөхцөл байдалтай танил байх шаардлагыг хангах үүднээс дотоодын зөвлөхүүдтэй хамтран ажиллахыг зохистойд үзнэ.

Худалдан авалт ТБТТ-ны хүрээнд хийгдэх аливаа худалдан авалтыг АХБ-ны Худалдан авалтын удирдамж (2015 оны хувилбар болон нэмэлт өөрчлөлтийн хамт)-ийн дагуу хийж гүйцэтгэнэ.

АХБ-ын хариуцсан Ажилтан

Шарад Саксена

АХБ-ны хариуцсан Газар

Зүүн Азийн Газар

АХБ-ны хариуцсан Хэлтэс

Тээвэр, харилцааны хэлтэс, ЗҮГ

Хэрэгжүүлэгч агентлаг

Зам, тээврийн яам

Хуваарь	
Концепцийг батлах	-
Урьдчилсан судалгаа	-
Менежментийн хяналтын уулзалт	-
Батлагдсан	2015 оны 7 сарын 29
Сүүлд хийсэн хяналт	-

ТА 8935-MON

Үе шатууд								
Батлагдсан огноо	Үзэглэсэн огноо	Хүчин төгөлдөр болсон	Хаасан					
			Анхны	Өөрчилсөн	Бодит			
2015.07.29	-	-	2016.12.31	-	-			
Санхүүжүүлэх төлөвлөгөө/ГТ-ны ашиглалт						Хуримтлагдсан зарлага		
АХБ	Хамтарсан санхүүжилт	Түнш				Нийт	Огноо	Дүн
		ЗГ	Үр ашгийг хүртэгчид	Төслийн спонсор	Бусад			
1,500,000.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	1,500,000.00	2015.07.29	0.00
ТМТ-г сүүлд шинэчилсэн огноо						2015.06.30		
Төслийн цахим хуудас		http://www.adb.org/projects/48329-001/main						
Мэдээлэл авах хаяг		http://www.adb.org/forms/request-information-form?subject=48329-001						
Анх үүсгэсэн огноо		2015 оны 8 сарын 14						

Төслийн Мэдээллийн Тайлан (ТМТ)–д төсөл болон хөтөлбөрийн талаарх хураангуй мэдээлэл багтдаг: ТМТ нь одоогоор хэрэгжиж байгаа ажлын тухай байдаг тул тайлангийн анхны хувилбарт зарим мэдээлэл багтаагүй байж болох ба бэлэн болсон үед нь нэмж оруулдаг. Санал болгож байгаа төслийн талаарх мэдээлэл нь урьдчилсан бөгөөд тойм шинж чанартай.

АХБ нь энэхүү Төслийн Мэдээллийн Тайлан (ТМТ)–г хэрэглэгчдэд гагцхүү мэдээллийн чанартай хүргэж байгаа бөгөөд ямарваа нэгэн амлалт, баталгаа өгөхгүй. АХБ нь өндөр чанарын мэдээллийн контент гаргахыг эрмэлзсэн хэдий ч тухайн мэдээллийг “байгаагаар нь” ойлговол зохих бөгөөд арилжааны шаардлагыг хангах, тодорхой зорилгоор ашиглахад нийцэх эсвэл бусдын эрхэд халдахгүй байх гэх мэт ямарваа нэгэн шууд болон шууд бус баталгааг өгөхгүй. Нэн ялангуяа, тайланд агуулагдсан мэдээлэл үнэн зөв бөгөөд бүрэн бүтэн болох талаар ямар нэгэн баталгаа эсвэл мэдэгдэл гаргаагүй болно.